

1962 оны 5-р сарын 31-нд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл, Хятад, англи янз бүрийн зүүлт, тайлбарыг орхин хэвлүүлж байна.

ТҮҮХЧДИЙН ИНДЭР

## ЧИНГИС ХААН ХЯТАДЫН ЭРДЭМТЭН ЧАН ЧУНЬ БОМБЫГ УРЬЖ УУЛЗСАН НЬ

**Н. Ишжамц\***

Чингис хаан монголын тулгар төрийг үндэслэн байгуулж, ойр, холын олон аймаг, улсыг нэгэн их гүрний дотор нэгтгэн захирахдаа цэрэг дайны болон гадаад харилцааны арга ухааныг нарийсган хэрэглэснээр үл барам тухайн үеийн элдэв шашны төлөөлөгчид, нэрд гарсан эрдэмтдийн нилээд хэсгийг биедээ татаж, төрийн хэрэгт туслуулан хэрэглэж чаддаг байжээ.

Ер нь Тэмүжиний Өэлүн эх болон Чингис хаан өөрөө оюун ухааны чадал, эрдэм мэдлэгийн хүчийг өндөр үнэлж тэтгэн дэмждэг байсан юм. Бага балчир насандаа Татарас олзлогдож Өэлүн эхийн гар дээр Чингис хааны дэргэд хүмүүжсэн Шихихутаг хэдийгээр Хятад, Уйгур зэрэг соёлт оронд очиж суралцсан удаагүй боловч тухайн үеийн их эрдэмтдийн зэрэгт хүрч, монголын эзэнт улсын цааз хууль, дотоод, гадаад бүх чухал хэрэг болон хааны ордны өдөр тутмын үйл явдлыг судар бичигт тэмдэглэн үлдээх улсын сударчийн үүрэг хүлээж байсан байна.

Урьд нь Хэрээд, Найман зэрэг нилээд соёлжсон монгол аймаг, улсуудад ажиллаж байсан Чинхай, Хадаг, Тататунгаа нар тэргүүтэй эрдэмтэн мэргэдийг Чингис хаан өөрийн дэргэд авч, хүвгүүд дүү нартаа бичиг үсэг заалгахаас эхлээд Монголын төрийн бусад хэрэгт чадамгай хэрэглэсэн юм. Түүнчлэн Хятадын соёлд нэвтрэн туулсан, хидан угсааны эрдэмтэн Елюй Чуцайг ивээн тэтгэж, төрийн зөвлөгчийн чанартай хүндэт байр суурь эзлүүлэн санал зөвлөлгөөнийг авч хэрэглэсэн нь үнэхээр чухал болсон юм. Ялангуяа хятад мэтийн суурьшмал соёлт орнуудын хувьд явуулах бодлогын талаар Елюй Чуцай олон зүйлийн үнэт зөвлөлгөөн өгч монголын төрд туслаж байжээ. Тийм ч учраас Елюй Чуцай монголд Цуу мэргэн гэж алдаршаад гадаадад мөн ихэд нэр гарчээ.

Ер нь Чингис хаан элдэв шашны төлөөлөгчид, эрдэмтэн мэргэдийн талаар ихээхэн нарийн бодлого явуулж, алсын хараатай ажиллаж байжээ. Энэ нь саяын ярьдаг шиг дэргэдээ байсан цэцэн мэргэдийг зөв зохистой хүндэтгэн хэрэглэж байснаар үл барам алс орны нэрд гарсан зарим эрдэмтнийг урьж авчирч уулзан, санал зөвлөлгөөн авч байсан явдлаас бас тодорхой харагдаж байна. Чингис хаанд тийнхүү уригдан очиж уулзсан эрдэмтдийн нэг нь Хятадын Чан Чүнь бомбо мөн.

Чан Чүнь бол 1148 онд умарт Хятадын Шаньдун мужид төрсөн хүн бөгөөд<sup>1</sup> Даосын суртахууны цагаан лянхын бүлгийг толгойлсон нэгэн даянч эрдэмтэн байжээ. Тухайн үедээ жинхэнэ үнэний мөрийг олж, нас уртасган амь мөнхжүүлэх арга ухаанд хүрсэн хүн гэж нийт Хятад даяар алдаршжээ.

\* ШУА-ийн гишүүн, доктор профессор

Умарт Хятадын Алтан улс, Өмнөт Хятадын Сүн улс хоёрын зүгээс түүнийг урьж удаа дараа дараалан элч зарсаар байсан боловч Чан Чүнь: «Миний явах зогсох цөм тэнгэрийн учир болай, Таны мэт жирийн хүний ухаж мэдэх зүйл биш. Гагцхүү үлдэж үл болох цаг болмогц явах болно, суух учиргүй» гэж буцааж байжээ.

Гэтэл 1219 оны зун Чингис хааны элч хүрэлцэн очиж Чан Чүнийг урьсан захиа гардуулан өгчээ. Тэр захианы үгийг монголчлон сийрүүлбэл ийн буюу:

«Тэнгэр бээр Дундат улсыг жигшин орхисон нь ихэмсэг бардам гоёмсог хээнцэр туйлдаа тулсны учир болай. Би бол умар газрын хээр талд сууж өчүүхэн ч шунахай ховдоггүй, харин даруу хялбарыг эрхэмлэн, элбэг тансагийг няцааж, арвич жирийн байдлыг дагамуй. Би хэзээ ч нэг янзын хувцас, нэг төрлийн хоолтой байдаг бөгөөд үхэрчин, адуучин лугаа адил хувцсалж ижил хоолломуй. Би ард иргэдийг нялх хүүхэд мэт энхрийлэн, эрдэмтэн мэргэдийг ах дүү шигээ тэтгэн дэмжмүй. Бид юу ч хийсэн санаа нэгтэй, харилцан бие биеийг өршөөн асрах сэтгэл түгээмэл бөлүгэ. Би түмэн цэргийг сурган боловсруулахад биеэр бүхний өмнө яван зуун давхар дайсны жагсаалд учравч ар талд хоцрохыг бодолгүй явсаар 7 жилийн дотор эзэн хааны гүйцэтгэх их үйлийг бүтээж 6 зүгийн дотроо агч улс орон бүгдийг нэгэн их гүрэнд багтаан нэгтгэв. Миний үйл явдалд эрдэм байснаар биш, Алтан улсын төр батгүй болсоны учир Тэнгэрийн ивгээл тэтгэлийг хүлээж эрхэм дээд сууринд хүрлээ. Өмнө зүгт Чжао овогийн Сүн улстай хил залгаж, умараа Хуйхэ уйгур нарыг нийлүүлж авмагц дорно этгээдийн Ся овогтон (хятад), өрнө талын харь (Н, И) аймгууд цөм биеэ боол шивэгчин хэмээх болов. (харьяат болж захирагдав, Н. И) Санавал манай Шаньюй (хүннүгийн хаан, Н, И) нарын улсаас хойш мянган жил зуун үе өнгөрхөд өөр тийм их улс байсан удаагүй. Иймд миний тушаал их, үүрэг хүнд болсон учир би засаг заслалыг тэгшлэн үйлдэхдээ алив зүйлийг дутуулуузай гэж аймуй. Мөрөн голыг гатлах гэвэл онгоц үйлдэж, сэлүүр бэлдэх лүгээ адил мэргэдийг залж туслагчаа сонгож олж байж сая дэлхий дахиныг түвшитгэмүй. Би хаан ширээнд сууснаас нааш төрийн хэрэгт сэтгэл тавин оролдовч гурван гүн, есөн цины<sup>2</sup> тушаалд тэнцэх хүн харагдсангүй. Сурвалжлан сонсвол эрдэмтэн багш Цю уай Та чин үнэний мөн чанарт нэвтэрч ёс жамыг сахиж явмуй; бодит юм, сонссон зүйл бүхнийг нарийвчлан мэдэж, далд учрыг ухан олж, зүй ёсыг шавхан ойлгожээ; ёс тань түгэн дэлгэрч эрдэм тань дуурьсан алдаршив. Та бээр эрт цагийн эрдэмтэн мэргэдийн чанд заншлыг хадгалж, жинхэнэ ихэс дээдсийн нарийн барилыг авчээ. Удтал уул хад, хавчил хөндийд орогнож суугаад биеэ нууж дүрсээ далдалжээ. Та өвөг дээдсийн үлдээсэн соёлыг нээн дэлгэж, суусаар агаад эрдэмтэй хүмүүсийг өөрийн зүг үүл хуралдах мэт цуглуулж ирүүлсэн нь тоолж баршгүй ажээ. Дайны үеэс хойш<sup>3</sup> Танийг Шаньдун мужийн хуучин хязгаарт хоргодон байгаа болохыг олж мэдээд би сэтгэлдээ агуулан санаж дуусах үгүй бөлгүэ. (Чжоу улсыг үндэслэн байгуулагч Вэнь ван. Н. И) Вэй голын эрэг дээрээс (загас барьж байсан Тайгүн гэгчтэй. Н. И) хамт нэгэн тэргэнд сууж ирсэн, (Хан улсын хууль ёсны удам төрөл Лө Бэй гэгч хүн Чжүгэ Лян мэргэнийг урьж. Н. И) гурван удаа гэрт нь очсон хэргийг сонсоогүй бишээ. Гэвч арга буюу уул мөрөн алслан зааглах тул биеэр угтах ёсыг алдах болохыг яая. Би гагцхүү уг сууринаас хажуу тийш зайлж мацаг барин биеийг ариутгаад шадар түшмэл Лю Чжүн-лүг сонгон зарж, жирийн морьтон, хөнгөн тэргийг бэлдүүлэн, мянган ли газрыг алс гэлгүй багш

Таныг хүндэтгэн урьж, хутагтын хөлийг түрчилээх гэнэм. Элсэн говийг алс хол гэж санаа зоволгүй, харин ард иргэдийг энэрэн үзэж энэ ертөнцийн хэрэгт оролцох ажаму. Эсхүл намайг хайрлан сэтгэж биеийг арилгах арга ухаан зааж өгмүү, би өөрийн биеэр эрхэм даянч таныг элбэрэн үйлчилнэ. Эрхэм багш Та надтай ярилцахын ялдамд (амь биеийг ариглах тухай Н. И) алив ганц үгийг нэмж хэлэвч тэр мөн хангалттай болно гэж би санагалзана. Эдүгээ би уг санааныхаа зарим зүйлийг цухуйлган хэллээ. Зарлигийн дотор тодорхой болсон байх гэж найдна. Багш Таныг их ёсны утга чанарыг илэрхийлэн сайнаар явж, үл зөвшөөрөх учир үгүй байх гэж үнэн бат найдан санана. Түүнээс гадна хүн ардын хүслэн мөрөөдлөөс гажин сөрж болмуу. Тийм учир зарлигийн утга санаа бүрэн ойлгомжтой байх ёстой гэж бодно. 5 сарын шинийн 1-нд (1219. 6. 14, Н. И.) бичив.,,

Энэ захианд Чингис хаан яах гэж Чан Чүнийг урьсан болох нь тодорхой байх мэт. Зарим зохиогч нар Чан Чүнийг Чингисийн урьсан гол зорилго гагцхүү амь насыг мөнхжүүлэх эм тан олж авах гэсэн хэрэг мөн гэж номлодог байв. Гэтэл Чингис хаан бол нас мөнхжүүлж болохгүй, хүн бүхэн заавал үхнэ гэгчийг сайн мэдэж байсан бөгөөд, энэ явдал дор дурьдсан зүйлээс баттай мэдэгдэж байна. Чан Чуньд дээрх захиаг бичсэний дараахан Чингис хаан Хорезмын эсрэг аян дайнд мордох болмогц Есүй гэдэг хатан нь хэрэв хааныг нас барвал аль хүргүүн тань залгамжлах юм бэ гэж асуужээ. Чингис хаан зарлиг болсон зүйлийнхээ дотор: «Хатан хүн боловч Есүйн үг зөвөөс зөв! Дүү нар, хөвгүүд, Бугурч, Мухулай Та нарын аль нь ч энэ үгийг дурьдгасангүй. Би өвгөдийн хойноос одохгүй (үхэхгүй. Н. И.) мэт, өөрөө мартсан ажээ. Үхэл надаас тойрох мэт үнэхээр үүнийг санасангүй»<sup>4</sup> гээд даруй хүвгүүд, дүү нартайгаа ярьж Өгэдэйг өөрийн залгамжлагчаар томилоод аян дайнд мордсон байдаг. Үүнээс үзэхэд Чан Чүнийг Чингис хаань амь насаа мөнхжүүлэх гэж уриагүй нь тодорхой болж байна. Ер нь ч Чингис хаан захидлынхаа дотор «биеийг ариглах арга ухааны» тухай цухас дурьдсанаас биш амь насыг мөнхжүүлэх гэж огтхон ч дурсаагүй билээ.

Чан Чүнийг Чингисийн урьдаг гол зорилго нь түүний эрдэм чадвар, түгээмэл нөлөөг монголын төрд ашигтай хэрэглэх гэсэн явдал болно. Бидний бодоход Чингис хааны захидлын үндсэн зүйл биеийг ариглах арга ухааны тухай цухас дурьдсан сүүлчийн ганц өгүүлбэр биш, харин «Санавал манай Шаньюй нарын улсаас хойш мянган жил зуун үе өнгөрөхөд өөр тийм их улс байсан удаа үгүй. Иймд миний тушаал их, үүрэг хүнд болсон учир би засаг заслалыг тэгшлэн үйлдэхдээ алив зүйлийг дутуулуузай гэж аймуй. Мөрөн голыг гатлах гэвэл онгоц үйлдэж сэлүүр бэлдэх лүгээ адил мэргэдийг залж, туслагчаа сонгон олж байж сая дэлхий дахиныг түвшитгэмүй. Би хаан ширээнд сууснаас нааш төрийн хэрэгт сэтгэл тавин оролдовч гурван гүн, есөн цины тушаалд тэнцэх хүн харагдсангүй. Сурвалжлан сонсвол эрдэмтэн багш Цю гуай Та чин үнэний мөн чанарт нэвтэрч ёс жамыг сахиж явмуй... Би... мянган ли газрыг алс гэлгүй багш Таныг хүндэтгэн урьж, хутагтын хөлийг түр чилээх гэнэм... ард иргэдийг энэрэн үзэж энэ ертөнцийн хэрэгт оролцох ажаму» гэсэн эхний хэсэгт байх мэт. Энэ хэдэн үгэнд Чингис хааны зүгээс Чан Чүнь бомбыг төрийн хэрэг, иргэний заслалд татан оруулж, эрдэм мэдлэг, хүч нөлөөгий нь ашиглан хэрэглэх гэсэн санаа илхэн байна.

Чан Чүнь бомбо, Чингисийн элчтэй уулзаж захидлыг үзээд өчүүхэн ч эргэлзэж татгалзсангүй, урьсан ёсоор хүрэлцэн очихыг зөвшөөрч да-

руй монголын зүг хөдөлжээ. Тэр анх Ляодуны хойг дээрээс гарсан бөгөөд зам зуур Бээжин хотод буугаад сонсвол Чингис хаан Хорезмын эсрэг аян дайнд мордож монгол нутгаас гарч баруун зүг алс одсон дуулджээ. 1220 оны 4 дүгээр сарын үес захиа явуулж хэрхэх учрыг лавлан асуусанд Чингис хаан түүнд үүл мэт хөнгөн тэргээ Энэтхэг орны зүг залж тогоруу ниссэн адил хурднаар морилон ирнэ биз гэж найдан хүлээж байна гэсэн хариу өгчээ.

Нас 70 гарсан өвгөн эрдэмтэн Чан Чүнь алсын зам дахь элсэн говь, ээрэм тал, өргөн гол, өндөр уулсыг давахад өдөр тутам тохиолдох элдэв бэрхшээлээс айж мөхсонгүй, Чингис хааныг хаа яваа газарт нь гүйцэж уулзахаар 20 гаруй шавь дагуулан хэсэг монгол цэргээр хамгаалуулж урам зоригтой хөдөлжээ. 1220 оны зун Бээжингээс гарч Цавчаал боомтыг өнгөрөөд, дараа жилийн 4-р сарын 24-ний өдөр Чингис хааны бага дүү Тэмүгэ Одчигиний өргөөнд хүрэлцэн очжээ. Тэмүгэ Одчигиний өргөө Бойр нуураас зүүн хойш байсан бөгөөд эргэн тойрон хэдэн мянган эсгий гэр, хар өнгийн гэр тэрэг хуралдаж буусан байжээ. Тэмүгэ Одчигинтэй уулзаад Оршуун голыг гаталж, Хүлүн нуурын урдуур гарч Хэрлэн голын өмнө эргийг даган баруун урагш оджээ. 1221 оны 6-р сарын дундуур үес Чан Чүнь нар одоогийн манай Улаанбаатар хот байгаа газрын урд талаар өнгөрчээ. Нутгийн ардууд түүний ирэх тухай нэг жилийн урьд сонссон байсан бөгөөд, идээ будаа барьж баяр баясгалантай угтаж аваад мөн дуу бүжгийн наадам зохиож ихэд хүндлэн үзэж өнгөрсөн байна. Мөн оны 7-р сарын 19-ний үеэр Хангайн нурууны зүүн хэсэгт, Орхоны хөндийд байсан Чингисийн хатны ордонд хүрэлцэн очжээ. Тэр хавьд хэдэн зуу буюу мянган гэр, тэрэг байсан бөгөөд ордны «буух асар, морилох жуузын сүрлэг сайхныг үзэхэд эртний Хүннүгийн их шаньюй нарынх ч тийм жавхлантай үгүй бөлүгэ». 8-р сарын эхээр Улиастайн дэргэдүүр өнгөрч Чинхай балгасны урдуур гарч явжээ. 8-р сарын дундуур Чинхай чинсан өөрөө хүрэлцэн ирж нийлээд Чан Чүньд бараа болон явж Чингис хаанд хүргэж өгөхөөр хамт хөдөлжээ. Улаан даваагаар Алтайг давж, Булган голын баруун эргийг барин явж, Өрөнгө голыг гаталж 9-р сарын дундуур үес Уйгурын нийслэл асан Бешбалык хотын тэнд хүрэлцэн очжээ. Тэндээс баруун тийш явж Талхи даваагаар давж, Или мөрнийг гатлан Алма-ата, Ташкент, Самарканд хотыг өнгөрч явтал 1222 оны 4-р сарын арван хэдэн, хоридын үеэр Чингис хааны элч тосч очжээ. Чингисийн хэлүүлсэн нь: «Үнэний эзэн Та наран мандах зүгээс гараад уулсыг даван, мөрөн голыг гаталж, туйлын их зүтгэн ядрав. Эдүгээ би нэгэнт нутаг буцах болж, Даогийн ёсны сургаал сонсохыг машид мөрөөдөн хүснэ. Алжаалгүй хүрэлцэн ирж намайг угтан уулзах буй за» гэжээ. Чингис хаан бас өөрийн есөн өрлөгийн ахмад, түмний ноён Буурчид Чан Чүнь бомбыг угтан очиж Төмөр хаалгын замаар хамгаалан гаргаж авчир гэж тушаан 1000 цэргийн хамт явуулсан нь 5-р сарын эхээр Чан Чүнийг Кеш хотод хүрэлцэн очиход угтан авч зам нийлжээ. 1222 оны 5-р сарын 15-ны үес Тэд Кабул хотын хойно Гиндүкүш уулын баруун хэсэгт буугаад байсан Чингисийн цэргийн хуаранд хүрэлцэн очжээ.

Хоёр, гурав хоносны дараа Чингис хаан өөрийн ордонд Чан Чүнийг урьж ирүүлэн аян замын амар мэндийг мэдээд, «Бусад улсаас өдий төдий урин залахад очихыг огт зөвшөөрөөгүй атлаа одоо Та түмэн газрын алсаас аялан хүрч ирсэнд асар ихээр баярлана би» гэж найрсаг хүндтэй хүлээн авчээ. Чан Чүнь хариулж үгүүлэхдээ «уулын зэрлэг би зарлигийг хүлээж хүрэлцэн ирсэн нь тэнгэрийн учрал болай» гэжээ. Чингис хаан баярлаж урьж суулган хоол унд өгүүлээд түүний зүг хан-

дан, «Үнэний эзэн Та алсаас хүрэлцэн ирэхдээ насыг уртасгах ямар эм тан надад өгөхөөр авчирав» гэж хошигнон асуужээ. Чан Чүнь «Биеийг арчлах арга зам буй, харин насыг уртасгах эм үгүй бөлүгээ» гэж хариулсанд Чингис хаан түүний үгийг сайшаан зөвшөөрчээ.

Чан Чүнь Чингис хоёрын гол яриа тэдний буцах замын зуур болсон байна. Гиндүкүшийн уулнаас бууж Самарканд хот орохдоо 1222 оны 10-р сарын 1-ний өдөр Чингис хаан аяны тэрэм асар бариулж засаад Чан Чүнь бомботой уулзаж ярилцжээ. Энэ удаагийн уулзалтанд Чан Чүнь бомбо Чингис хаанд Даосын ёсны тухай ярьж өгчээ. 10-р сарын 5-ны өдөр Чингис хаан бас Чан Чүнийг урьж Даосийн ёсны тухай нягтлан хэлцэж нарийвчлан ярилцжээ. Дараа нь 10-р сарын 9-нд Чингис, Чан Чүнь нар бас уулзаж Даосын ёсны тухай ярилцжээ.

Даосын сургаалд ялангуяа Чан Чүнийн үед хүний амь насыг бататгах тухай онол чухал суурь эзэлдэг байсан, нөгөө талаар энэ асуудлыг Чингис хаан бас сонирхож байсан учир Чан Чүнь Чингис хоёрын Даосын ёсны тухай эхний гурван ярианд амь биеийг асран тэтгэх арга ухааны талаар нилээд сэдэв авсан болтой. Чингис хаан дээрх гурван удаагийн ярианы тухай дэргэдэх хүмүүст хэлэхдээ: «Хутагт даянч амь биеийг асран тэтгэх арга замын тухай гурван удаа ярьж өглөө гэсэн байна.

Гэвч цаашдаа тэд дан ганц амь насны яриа яриад байсангүй Даосын сургаалын бусад талын асуудлуудыг голлож ярилцсан байна. Тэр тухай Чан Чүнийн замын тэмдэглэлд дурьдсан нь: «Зарим үес Даосын ёсыг дэлгэрүүлэн айлтгаж байв» гэжээ. Даосын соёл гэдэг үгийн агуулгад ганц амь насны асуудал биш, харин байгаль, нийгэм, сэтгэхүйн холбогдолтой олон зүйлийн онол сургаал багтаж байсан юм. Тийм учир Чингис хаан, Чан Чүнь бомбо хоёрын ярианд тэнгэр дуугарах, цахилгаан цахих, аянга буух тухай асуудал хүртэл орсон байна. 1223 оны 1-р сарын 31-ний өдөр Самарканд хотоос нааш ирж явах замдаа Чингис хаан Чан Чүнь бомбоос тэнгэрийн дуу, аянга цахилгааны тухай асуужээ. Чан Чүнь түүний асуултанд шууд тодорхой хариу өгсөнгүй, харин Монголчууд аянга цахилгаанаас айдаг явдал бол «Тэнгэрийг хүндэтгэх ёсон биш» гэж зуны цагт тэнгэрээс айж мөөг түүхгүй, эсгий хийхгүй байх зэргийг буруушаасан байна.

Чан Чүнь Чингис хоёрын бүх ярьсан зүйл бүрэн тэмдэглэгдэж үлдсэнгүй, тийм учир тэд чухам юуны тухай ярьсан, юуны тухай яриагүй вэ гэдгийг нарийн мэдэхэд бэрх юм. Гэвч тэдний ярьсан зүйл зөвхөн дээр дурьдсан хэдэн зүйлээр хязгаарлагдаагүй нь мэдээжийн хэрэг. Нэгэн талаас Чингис хаан алив юмны учрыг ихэд сонирхон зориуд Чан Чүнийг урьж авчирсан, нөгөө талаар Чан Чүнь бол тухайн үеийн хятадын соёл эрдмийг нэвтэрхий мэдсэн хүн байсан тул тэдний ярьсан зүйлийн хүрээ нэн өргөн байсан гэмээр. Чан Чүний мэдлэгийн хэмжээ, ажин шинжих их авьяас чадварыг харуулсан нэгэн баримтыг дурьдахад сонин болно. Чингистэй уулзахаар явах замд Хэрлэн голын дунд урсгал орчим явахад нь 1221 оны 5-р сарын 23-ны жин үдийн морин (12 цаг) цагт нар бүтэн хиртэж, тэнгэр бүрий баруй болоод одон мичид харагдаж байжээ. Гэтэл Алтайн нуруунд хүрээд мөн өдрийн нар хиртэлтийн тухай хүнээс асуувал могой (10 цаг) дагт хиртсэн, гэвч бүтэн хиртээгүй, аравны долоон хувь нь сүүдэртсэн гэж байжээ. Дараа Самарканд хот хүрээд тэндэхийн нэгэн зурхайчаас сонсвол нар 8 цагийн үед хиртэж тавны гурван хувь нь халхлагдсан гэжээ. 1221 оны 5-р сарын 23-ны нар хиртэлт тийнхүү хэдэн газар өөр өөр цагт бүтэн,

хагас янз бүр болж өнгөрснийг ажиж мэдээд Чан Чүний өгүүлсэн нь: «Ийнхүү гурван газарт гурван янзаар үзэгдэв. Күн Инда (574-648 оны үеийн хятадын их эрдэмтэн Н. И) Цюньцю (хавар намар-Күнзын зохиол Н. И) номонд тайлбар хийхдээ «Сарны бие нарыг халхлан сүүдэрлэмэгц наран хиртмүй» гэсэн байдаг. Эдүгээгийн байдлаас авч үзвэл халхалсан газрын доор байгч хүн нарны хиртэхийг олж үзмүй. Түүнээс хажуу тийш агчидад алслан холдох тутам аажмаар улам бүр өөр болж үзэгдмүй. Төв хэмээн дэвүүрээр дэнгийн гэрлийг халхлах адил: Дэвүүрийн сүүдэр туссан газарт дэнгийн гэрэл эс үзэгдьюү. Түүнээс хажуу тийш холдох тусам дэнгийн гэрэл нэмүү харагдмүй» гэжээ. Үүгээр үзвэл Баруун Европт гагцхүү XVII зууны үед нээн олсон, наран хиртэхийн нарийн учрыг Чан Чүнь бомбо сайн мэдэж зөв тайлбарлаж байсан байна.

Чан Чүнь бомбын эрдэм мэдлэгийг Чингис хаан угаас өндөр үнэлж байсан бөгөөд өөртэй нь уулзаж ярилцсаны дараа улам өндөр үнэлэн хүндэтгэх болсон юм. Чингис хаан нэг өдөр хан хөвгүүд, ноёд түшмэдийг цуглуулаад Чан Чүнь бомбын тухай өгүүлэхдээ «Та нар тэнгэрийг хүндлэхийн нэгэн адилаар хятадууд хутагт даянчийг (Чан Чүнь бомбыг. Н. И бишрэн хүндэлмүй. Түүний үнэхээр тэнгэрлэг их хүн мөн гэдэгт би эдүгээ улам итгэх болов» гэж байжээ.

Чан Чүнь бомбын яриаг Чингис ихэд сонирхон сонсдог байсан бөгөөд онол мэдлэгийн холбогдолтой зүйлсийг дахин дахин тайлбарлуулж бүгдийг тусгай бичээч нар суулган тэмдэглүүлж авсан байна. Чан Чүнь бомбын хийсэн онолын холбогдолтой анхны гол яриануудыг хятад үсгээр хятад хэлэн дээр нь тэмдэглүүлж, бас монгол орчуулгыг уйгуржин монголоор бичүүлж авчээ. Дараачийн бүх яриануудыг уйгуржин монголоор тэмдэглүүлж авчээ. Түүнчлэн ярианд оролцсон бүх хүмүүст Чан Чүний хэлсэн зүйлийг тэмдэглэн бичиж авах, цээжлэн санаж явах шаардлага тавьж байжээ.

Чан Чүнь бомбо Чингис хааны дэргэд 8 сар шахам болсоны дараа, 1223 оны 3-р сарын 13-ны өдөр нутгийн зүг буцах тухай айлтган мэдүүлжээ. Чингис хаан «Гурав юм уу тав хоногийн дараа хан хөвгүүд хүрэлцэн ирэх болтол хүлигэлэмүү. Даосын ёсны тухай урьд ярьсан ярианаас ойлгогдоогүй зүйлийг миний ухаж мэдсэний дараа явагтүн» гэжээ. Чингис хаан Чан Чүнь бомбыг нутгийн зүг яаран буцаах дуртай биш байсан бололтой. Гагцхүү 3 дахь удаагаа гуйхад зөвшөөрсөн байна.

Чан Чүнь бомбо 1223 оны 4-р сарын 12-нд Чингис хаантай салахын ёслол гүйцэтгээд нутгийн зүг морджээ. Алтайг өнгөртөл урьдын ирсэн замаар яваад Чинхай балгасны орчмоос зүүн урагш эргэж Хөх хотоор дайраад 1224 оны 3-р сарын үес Бээжинд хүрэлцэн очжээ. Түүнийг Чингис хааны зарлигаар томилогдсон түшмэд, цэрэг хүргэж өгсөн юм.

Чан Чүний нутаг буцахад Чингис хаан шавь нарыг нь бүхийлэн төрлийн албанаас чөлөөлсөн тамгатай бичиг үйлдүүлж өгсөн байна. Замд явахад хэдэн удаа захиа бичсэн байх бөгөөд анхны захидлын дотор дурьдсаныг үзвэл «Хутагт даянч Та хятад газартаа хүрч очоод ариун тунгалаг Даосын сурталтан хүмүүсээр миний насан хутгийг уртасгахын төлөө богд номыг уншуулан мөргүүлж байвал маш сайн байна. Хутагт даянч аль аятай санагдсан газартаа суугтун. Танай насан хутаг өндөр болсон тул асарч сайн тэтгэ гэж Алисянд (Чан Чүнийг хүргэсэн хүн. Н, И) захьсан. Хутагт даянч Та миний урьдын хэлсэн үгийг бүү умарт» гэсэн байна. Дараачийн нэг захидлын дотор «Хутагт даянчийг салж одсоноос хойш би ганц ч өдөр мартсан удаа үгүй, Ху-

тагт бас намайг мартаагүй буй заа. Миний мэдлийн газар хаа хүссэн нутагтаа суугтүн. Харин шавь нар тань богд номыг уншиж миний насан хутагийг бататгах мөргөл хийж байвал сайн сан» гэжээ. Энэ бүхэн Чингис хаан Даосын шашны дэмжлэгийг олохын тулд Чан Чүнь бомбыг хүндэтгэн урьж Даосын шашныг дэмжсэн нь гол төлөв төрийн нарийн бодлогын учир үйлдсэн явдал мөн.

Даосын шашны талаар Чингисийн явуулсан бодлого зохих үр дүнгээ өгсөн гэвэл зохино.

Чан Чүнь бомбо Монголын байлдан дагуулагчдыг асар идэвхтэй дэмжээгүй боловч эсэргүүцэхгүй байснаар үл барам Чингис хаантай байнгын холбоо барьж, бас ч ажил явдалд нь тусламж дэмжлэг болох санал зөвлөлгөөн өгөх болжээ. 1223 оны 10-р сарын үес Чингис хаан Чан Чүнь бомбод илгээсэн нэг захидлынхаа дотор «Хутагт Цю (Чан Чүнь. Н. И даянчаас албан хэргийн тухай мэдүүлэн айлтгаж ирсэн зүйл мөн тул сайн байна» гэснээс үзвэл Чан Чүнь Чингис хаантай харилцаж албан хэргийн талаар санал зөвлөлгөө өгч байсан ажээ. Ялангуяа цаашдаа Чингис хаан Чан Чүнь бомбоор нийт хятадын Даосын сурталтан нарыг ерөнхийлөн захируулсан нь Чан Чүний зүгээс монголын төрд нилээд талтай буюу ер нь нилээд тустай байсныг давхар нотолж байна.

Чан Чүнь бомбо шавь нараа алив бүх албанаас чөлөөлүүлж буцаж ирсэний дараа шинэ шавийн тоо түргэн нэмэгдэн умард хятад даяар Даосын шашин түгэн дэлгэрч эхэлсэн байна, «Тэрбээр (Даосын суртал. Н.И) дөрвөн зүг найман зовхист урьдаас зуу дахин өргөн дэлгэрэв» Гэтэл Даосын шашныг Чингис дэмжиж тийм болгосон, багш (Чан Чүнь) нь Чингистэй байнга харилцан, зарим үед шууд дэмжиж байсан учир тэр олон Даосын сурталтан монголын төрд дургүйцэн эсэргүүцэл гаргахыг больж харин талархан дэмжих тийш хандсан байна. Чухам энэ явдал Чингис хаанд хэрэгтэй байсан бөгөөд гагцхүү үүний учир Чингис хаан Даосын шашныг дэмжих болсон юм.

Гэвч Хятадад даосын ёсноос күнзын суртал хол илүү нөлөөтэй байсан атал Чингис хаан яагаад түрүүчийнхийг онцлон дэмжих болов? Хэрэв анхнаасаа монголчуудыг күнзын сурталтангууд шийдвэртэй эсэргүүцэж, Даосын ёсны бомбо нар талархан дэмжиж байсан бол хэргийн учир тодорхой байсан. Гэтэл үнэн хэрэг дээрээ харин даосын ёсыг сахигчид нь өөрийн улсын тусгаар тогтнолын төлөө харийн дайсны эсрэг илүү шийдвэртэй тэмцдэг байсан билээ. Иймд Чингис хаан чухам тэдний хувьд улам нарийн бодлого явуулж, тэднийг талдаа татан авах зорилт тавьсан байж болно. Нөгөө талаар Чингис хаан «Мысли в духе Дао дэ, искренно скажу, заслуживают уважения (Даосын ёсны санаа бодол бол үнэн сэтгэлийн угаас хэлэхэд хүндэтгэвэл зохих зүйл юм)» гэж үздэг байжээ. Чингис хаан Чан Чүньтэй уулзаад даосын ёсны онол, мэдлэгийн талыг онцгой сонирхон тайлбарлуулж байснаас үзвэл саяын иш татсан үг хуурамч яриа биш байна. Даосын сургаал чухам яагаад Чингисийн таалалд тэгж сүрхий нийлэх болов гэдэг асуудал тодорхойгүй, гэвч хамгийн сонин бөгөөд чухал нь Чингис хаан түүнийг үнэхээр ихэд сонирхон хүндэлж үздэг байсан явдал болно. Даосын суртал уг нь манай эриний өмнөх VI-V зууны үед үүссэн бөгөөд анхандаа материалист гүн ухаан байсан юм. Гагцхүү хожмын үед шашны нөлөө нэвтэрхий шингэж шашны сургаал болж хувирсан боловч анхны материалист шинж чанарын зарим зүйл нь хэвээр үлдсэн байв. Байгаль ертөнцийн хэсэг үзэгдлийг материалист ёсоор зөв тусган ойлгох

талаар Даосын сурталт бомбо нар күнз, мэнзийнхээс нилээд талаар илүү байсан билээ.<sup>5</sup>

Гэвч энэ байдлыг ялангуяа тэр үед Монгол шиг харь газрын нүүдэлчин малчдын зүгээс ойлгон мэдэхэд үнэхээр бэрх байсан юм. Гэтэл Чингис хаан хэргийн учрыг тоймлон мэдэж Даосын ёс, Чан Чүнь бомбыг дэмжин тэтгэсэн байна. Тэр үеийн хятадын олон суртал дотроос чухамхүү материалист гарал язгуур бүхий Даосын ёсны чадалтай талыг тийн мэдэж, үй түмэн хушан, бомбо нарын дундаас наран хиртэх нарийн учрыг зөв ойлгосон Чан Чүнь шиг их эрдэмтнийг сонгон олж чадсан нь Чингис хааны зүгээс алив юмны учрыг ухан ойлгох, ялангуяа хүний чанар чансааг танин мэдэж, зохих байрыг зөв эзлүүлэн хэрэглэж чаддаг төрийн их хүний ховор нандин чадвар бүхий явдал нэг бус удаа илэрсний тодорхой баримт мөн бөгөөд Чингисийн тийм хурц авьяас, мэргэн хараа нь монголын тулгуур төр үүсэн мандахад ямар ч хүний хичнээн ч их цэргийн чадвараас дутуугүй үүрэг гүйцэтгэсэн болохыг тэмдэглүүштэй.

1. E. Bretshneider M. D. Medieval researches from eastern Asiatic sources, Vol 1, London, 1910, 35-р тал
2. Эртний Хятадын төрийн хамгийн дээд тушаалын түшмэд сайдуудыг тэгж нэрлэдэг байсан юм.
3. 1215 онд Алтан улсыг байлдсан тухайгаа ярьж байна.
4. Монголын нууц товчоон, Ц. Дамдинсүрэн 250-р тал.
5. Ян Хин шүн. Древне-китайский философ Лао-Цзы и его учение. М-Л., 1950

**БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД БОДЛОГЫН ТУХАЙ  
(1911—1919)**

**Ц. Пунцагноров\***

VIII Жавзундамба хутагтын улс төрийн үзэл бодол манжийн Дайчин гүрнээс XIX зууны хоёрдугаар хагасаас Монголд «шинэ бодлого» явуулсан үед бүрэлдэн тогтсон юм. «Шинэ бодлого» гэгч нь эцсийн бүлэгт Монголын үндэсний гал голомтыг унтраахад чиглэснийг хутагт ойлгож манжийн ноёрхлоос ангижирч үндэсний тусгаар тогтнолыг сэргээх арга замыг хайж эхэлсэн юм. Тэгэхдээ гаднаас авах дэмжлэгийг онцгой анхаарч байжээ. Тэрээр Монгол орон хоёр том гүрний хооронд оршдог болохоор тусгаар тогтнолоо тэмцэн олох, түүнийг батлан хамгаалахад умард хөрш-хаант Орос улсын дэмжлэг зайлшгүй хэрэгтэйг гүнзгий ухамсарлажээ.

Богд гэгээн 1895 онд Их Шавийн даа лам Бадамдоржийг Орос улсад нууцаар явуулж Цагаан хаанд бараалхуулан Монгол орныг Манжийг захиргаанаас гаргаж тусгаар улс болоход нь Чин улсад зуучлахыг хүсчээ. Хэрэв манж нар Монголын тусгаар тогтнох эрмэлзлийг хүч хэрэглэн дарахыг завдвал Оросоос цэргийн тусламж гуйна гэжээ. Тусгаар тогтносон Монгол улсын нутаг дэвсгэрийн өмнө зах хязгаарыг цагаан хэрмээр тогтоож монголчуудын эртний нутгийг бүрэн эзлүүлэх бодолтой байжээ.

\*ШУА-ийн гишүүн, Энэ илтгэл нь 1992 оны 8 сард хуралдсан Олон улсын Монголч эрдэмтдийн VI их хуралд тавигдсан бөгөөд зохиогчийн хүсэлтээр бүрэн эхээр нь нийтлэв. Илтгэлд тусгагдсан үзэл бодол зөвхөн зохиогчийн бөгөөд сэтгүүлийн редакцийн биш гэдгийг уншигчид болгооно бизээ.